

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХ ЗАР

2025 оны 04 дүгээр сарын 01

Мандалговь хот

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- ✓ төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- ✓ Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- ✓ Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх

Бүрдүүлэх материал:

- ✓ Шилжин ажиллах хүсэлт
- ✓ Төрийн албан хаагчийн анкет;
- ✓ Иргэний үнэмлэхийн хуулбар;
- ✓ Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- ✓ Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- ✓ Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- ✓ Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- ✓ Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- ✓ Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- ✓ Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх болон байгаа эсэх тухай тодорхойлолт /бүртгэл явагдаж байх хугацаанд e-mongolia-аас татан авах/.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох баримт
- ✓ Цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэний хувьд цэргийн үүрэгтний үнэмлэх

Материал хүлээн авах:

Хугацаа: Шилжин ажиллах хүсэлтийг тухайн байгууллагын цахим хаяг /зард дурдсан/-аар 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 04 дүгээс сарын 07-ны өдрийн 17.00 цаг хүртэл хүлээн авна.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ СУЛ ОРОН ТООНД ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ

2025 оны 04 дүгээр сарын 01

Мандалговь хот

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага				Хүсэлт ирүүлэх байгууллагын цахим хаяг, утасны дугаар
					Төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Ахлах түшмэл удирдах											
1	Цагаандэлгэр сумын ЗДТГ		Засаг даргын Тамгын газрын дарга	1	Удирдах	ТЗ-5	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй	Эрх зүй /042/ Төрийн удирдлага /041303/ Боловсрол /011/ Хүнс, хөдөө аж ахуй, мал эмнэл зүй /08/ Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал /09/ Нийгмийн шинжлэх ухаан /03/ Мэдээлэл, харилцаа холбооны технологи /061/ Хүрээлэн буй орчин /052/ Нягтлан бодох бүртгэл, татвар /0411/	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.	Шилжих, сэлгэн ажиллах санал ирүүлэх хаяг: Solongo@tsagaandelger.gov.mn Холбоо барих утас: 88086095
Дэс түшмэлийн гүйцэтгэх											
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Нийгмийн халамжийн хэлтэс	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	1	Гүйцэтгэх	ТЗ-9	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал /102201/ эрхзүй /042/, боловсрол /011/.	Шаардахгүй	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	Шилжих, сэлгэн ажиллах санал ирүүлэх хаяг: info@Dundgovi.hudulmur-halami.gov.mn
2			Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд жуулчлал	1	Гүйцэтгэх	ТЗ-9	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	Эдийн засаг /0311/ Эрх зүй /042/ Менемент ба удирдахуй /041301-041303/	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан	Холбоо барих утас: 70593986, 99800657, 88098952

			хариуцсан мэргэжилтэн					Боловсрол /011/ Сэтгэл судлал /0313/		бол давуу тал болно.	
3	Дэрэн сумын Засаг даргын Тамгын газар	Хөдөө аж ахуйн тасаг	Малын, үржил бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	Гүйцэтгэх	ТЗ-9	Дээд боловсролтой байх	Мал аж ахуй /081101/ Мал зүй /081102/ Мал амьтны гаралтай түүхий эд судлал /081104/ Тэжээл, бэлчээр судлал /081103/	Шаардахгүй	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	Шилжих, сэлгэн ажиллах санал ирүүлэх хаяг: zulbaatar@deren.du.gov.mn Холбоо барих утас: 99302465
4	Дэлгэрхангай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал		мэргэжилтэн	1	Гүйцэтгэх	ТЗ-9	Дээд боловсролтой байх	-Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй /03/ -Мэдээлэл харилцаа холбооны технологиуд /06/ -Боловсрол /01/ -урлаг, хүмүүнлэг /02/ -байгалийн шинжлэх ухаан /05/ -бизнес ба удирдахуй, эрх зүй /04/ -инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт /07/ -эрүүл мэнд, нийгмийн хамгаалал /09/ -үйлчилгээ /10/ -хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй /08/	Шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх	-Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	Шилжих, сэлгэн ажиллах санал ирүүлэх хаяг: muug.ith@gmail.com Холбоо барих утас 98908187, 80908187
5	Хүнс хөдөө аж ахуйн газар	Үйлдвэр худалдаа үйлчилгээ ний хэлтэс	Хүнс хоол үйлдвэр үйлчилгээ худалдааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	1		ТЗ-9	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Хүнс боловсруулалт /0721/ -Хүнсний биотехнологи /078802/ -Хүнсний микробиологи /078803/	Шаардахгүй	-Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно	Шилжих, сэлгэн ажиллах санал ирүүлэх хаяг: info@du.hhaag.gov.mn Холбоо барих утас: 88005893, 91915707

								-Мах сүү үйлдвэрлэлийн технологи /081105/ -Мал амьтны гаралтай түүхий эд судлал /081104/			
6			Хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн	1		ТЗ-8	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	Хөнгөн үйлдвэрийн технологи /0723/ -Эдийн засаг /0311/ -Менежмент ба удирдахуй /0413/ -Нягтлан бодох бүртгэл, татвар /0411/ -Статистик /0542/ Мал амьтны гаралтай түүхий эд судлал /081104/	Шаардахгүй	-Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно	

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ